

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тосон илч” ОНӨААТҮГ -ыг 2025 оны санхүүгийн тайлан,
тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан.

Аудитын код: ХӨА-2026/016/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: Erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн захирал: Д.Мягмарсүрэн
Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/304
танай _____-ны № _____-т

“ТОСОН ИЛЧ” ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ДАВААХҮРЭЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тосон илч” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Тосон илч” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөвсгөл аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 06/24 дүгээр тогтоолоор “Тосон илч” ОНӨААТҮГ-ын халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон байна. Тайлангийн хугацаанд үнэ тарифт өөрчлөлт ороогүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 132,645.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 129,167.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 материаллаг бус зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 3,477.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Бусад асуудлын хэсэг

“Тосон илч” ОНӨААТҮГ-ын тайлант оны орлогын төлөвлөгөөг 12,683.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, зардлыг 29,383.4 мянган төгрөгөөр хэмнэсний дүнд 58,105.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,524,055.37	437,028.91
1.1.2	Дансны авлага	23,442,458.80	225,330,271.19
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	13,632,972.92	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	59,968,402.57	56,077,892.94
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	104,567,889.66	281,845,193.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	344,157,475.23	290,873,250.99
1.2.2	Биет бус хөрөнгө	13,572,000.00	13,572,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	357,729,475.23	304,445,250.99
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	462,297,364.89	586,290,444.04
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	70,464,916.77	86,740,105.53
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	2,998,604.11	40,093,900.16
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	73,463,520.88	146,225,893.27
2.2	Өр төлбөрийн нийт дүн	73,463,520.88	146,225,893.27
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	264,339,132.91	264,339,132.91
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- Хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,913,603.18	14,913,603.18
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	109,581,107.93	160,808,260.69
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	388,833,844.02	440,060,996.78
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	462,297,364.90	586,286,890.05

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	567,184,788.18	746,815,244.76
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	546,507,634.79	525,101,259.76
3	Нийт ашиг (алдагдал)	20,677,153.40	221,713,985.00
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00

7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	65,987,956.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	136,417,277.93	163,608,011.78
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(49,752,168.53)	58,105,973.23
19	Орлогын татварын зардал	0.00	6,878,820.47
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(49,752,168.53)	51,227,152.76
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(49,752,168.53)	51,227,152.76
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(49,752,168.53)	51,227,152.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	619,293,128.51	622,645,292.85
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	618,640,370.51	619,195,292.85
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	106,958.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтын орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	545,800.00	3,450,000.00
1.2	Мөнгөн зарлага (-)	614,934,242.20	617,132,319.30
	Ажиллагчдад төлсөн	249,676,007.32	225,904,086.57
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	35,443,115.22	47,881,531.79
	Бараа материал худалдан авахад төлсөн	112,898,847.50	105,301,552.00
	Ашиглалтын зардалд төлсөн	68,840,888.91	75,719,426.83
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	88,293,218.00	102,616,929.40
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	33,728,076.74	38,577,856.71
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
	Бусад мөнгөн зарлага	26,054,088.51	21,130,936.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,358,886.31	5,512,973.55
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00

	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	181,553,000.00	12,600,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	181,553,000.00	12,600,000.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(181,553,000.00)	(12,600,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахал төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(177,194,113.69)	(7,087,026.45)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	178,582,969.68	7,524,055.37
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,388,855.99	437,028.91

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18	209,249,812.17	473,290,948.26
2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18	209,249,812.17	473,290,948.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	51,227,152.76	51,227,152.76
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18	260,476,964.93	524,518,101.02

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төгрөгөөр

№		Үзүүлэлтүүд	Бүгд дүн / төг/			Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1. Нийт зардал						
1	Цалин	303,581,953.30	225,904,086.57	77,677,866.73	74%	
2	НДШ	40,983,563.70	47,881,531.79	-6,897,968.09	117%	
3	Ажиллаагүй үеийн НДШ	3,474,900.00	3,474,900.00	0.00	100%	
4	Цахилгааны зардал	80,926,800.00	90,926,000.00	-9,999,200.00	112%	
5	Албан томилолт	1,990,000.00	1,326,784.00	663,216.00	67%	
6	Шуудан холбоо	1,508,400.00	990,000.00	518,400.00	66%	
7	Бичиг хэрэг	1,035,000.00	433,385.37	601,614.63	42%	
8	Хөдөлмөр хамгаалал	11,159,500.00	7,684,000.00	3,475,500.00	69%	
10	Шатахууны зардал	8,728,000.00	8,153,825.00	574,175.00	93%	
11	Нүүрс зардал	55,235,000.00	69,554,422.49	-14,319,422.49	126%	
12	Нүүрс тээврийн зардал	103,182,500.00	96,785,500.00	6,397,000.00	94%	
14	Үндсэн хөрөнгийн элэгдэл	62,876,144.90	67,866,042.42	-4,989,897.52	108%	
15	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	10,255,500.00	12,500,000.00	-2,244,500.00	122%	
16	Сан техникийн сэлбэг	11,159,500.00	7,439,519.71	3,719,980.29	67%	
17	Авто сэлбэг	4,219,000.00	1,500,000.00	2,719,000.00	36%	
20	Төлбөр хураамж, татвар, даатгал	6,950,190.00	6,950,190.00	0.00	100%	
22	Тэтгэмж, дотоод журам	23,296,000.00	24,757,266.00	-1,461,266.00	106%	
23	Хөрөнгө оруулалт	39,700,000.00	14,581,818.18	25,118,181.82	37%	
24	ТУЗ-ЫН ЗАРДАЛ			0.00		
Нийт зардлын дүн		730,561,952.00	688,709,271.53	41,852,680.47	94%	
2. Нийт борлуулалтын орлого						
1	Төсөвт газар	652,413,600.00	652,821,631.80	-408,031.80	100%	
2	Аж ахуйн нэгж	34,584,368.00	37,584,000.00	-2,999,632.00	109%	
3	Айл өрх	8,013,984.00	8,891,449.20	-877,465.20	111%	
4	Түрээс	840,000.00	1,147,272.70	-307,272.70	137%	
5	Халуун ус	19,200,000.00	17,279,944.46	1,920,055.54	90%	
6	Цэвэр ус	19,080,000.00	28,090,946.57	-9,010,946.57	147%	
Нийт борлуулалтын орлогын дүн		734,131,952.00	746,815,244.76	-12,683,292.76	102%	
Нийт зардлын дүн		730,561,952.00	688,709,271.53	41,852,680.47	94%	
Ашиг ,алдагдал		3,570,000.00	58,105,973.23	54,535,973.23	0.07	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 132,645.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 129,167.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, материаллаг бус зөрчилд 2 албан шаардлага, 3,477.6 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тус тус өгсөн.

Залруулсан алдаа:

- Татварын тайлангийн орлого, санхүүгийн тайлангийн орлого 129,167.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 5.1.5-д "хэмжигдэхүйц байх"; 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 65 дугаар зүйл НББ-ын зарчим дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт зөрчигдөж байна.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй байна.

3.2 Албан шаардлага.

1. Тайлангийн хугацааны эцэст 6,932.6 мянган төгрөгийн авлага, 32,440.7 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Шилэн дансанд 2 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан зэрэг нийт 157 мэдээ мэдээлэхээс 16 мэдээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөрчил таслан зогсоох албан шаардлага өгсөн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 74 101.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 16 нэр төрлийн 18 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалт зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх.

2. Цалингийн данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 3,395.5 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5-д "цалин

хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн хүснэгтээр тооцоолсон дүнг үнэн зөв тайлагнаж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын тайлангийн орлого, санхүүгийн тайлангийн орлого 129,167.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна.	1	129,167.6			1	129,167.6	1	129,167.6
Дүн	1	129,167.6			1	129,167.6	1	129,167.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	-			1	-		
элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй хөрөнгө	1	-					1	-
НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 3 395.5 мянган төгрөгийн зөрүүтэй.	1	3,477.6					1	3,477.6
Дүн	3	3,477.6			1	-	2	3,477.6

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн	Тоо	Дүн	Дүн
Санхүүгийн аудитын зөрчил								
Шилэн дансанд хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан зэрэг нийт 157 мэдээ мэдээлэхээс 16 мэдээг мэдээлээгүй байна.	1	-			1	-		
Нийт дүн	1	-	-	-	1	-		

